

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№18/479

ШУС, НУС

2017

**ХЯТАДЫН ЦАХИМ СЭТГҮҮЛ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,  
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**

Б.Болд-Эрдэнэ\*, Уяхан(БНХАУ)\*\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор

\*\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

**Түлхүүр үг:** цахим сэтгүүл зүй, нэг цэгийн онлайн үйлчилгээ, хайлтын систем

**М**эдээлэл харилцаа улам бүр даяаршиж, мэдээллийн технологийн хөгжил дэвшлийн үр шим хүний өдөр тутмын хэрэглээнд асар хурдтай нэвтэрч байгаа энэ үед хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиглалтад ч түүнийг дагасан тодорхой өөрчлөлт гарч байна.

Монголд интернетийн хэрэглээ хэвлэл мэдээллийн асар их дэвшлийг дагуулж байна. Интернет сүлжээний үр дүнд бий болсон цахим сэтгүүл зүй нь нэгэнт хэвлэл мэдээллийн салбарын нэг болохын хувьд нийгмийн сэтгэл зүй, олны санаа бодлыг төлөвшүүлээд зогсохгүй түүнийг залж чиглүүлэх нөлөө бүхий удирдлагын хэрэгсэлд тооцогдох нь зүй.

“Хэвлэлийн хүрээлэн”-гийн судалгаагаар тус улсад үйл ажиллагаа явуулж буй 485 мэдээллийн хэрэгсэл байгаа-

гаас сонин 101, телевиз 131, радио 69, сэтгүүл 86, сайт 98 байна. Түүнчлэн 100 орчим албан ёсны цахим сайт тогтмол үйл ажиллагаа эрхлэхээс гадна радио болон хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг ашиглах нь багасч, мөн сонин борлуулалт дэлхийн бусад орнуудын нэгэн адил буурч байгаагийн нөлөөгөөр “цаасан хэвлэлээс цахим руу” давалгаанд Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч шилжиж эхэлж байна. Цахим сэтгүүл зүй үндсэн хоёр үүрэг гүйцэтгэж байгаагийн нэг нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн орон зайг тэлэх юм. Сонинуудын 45 хувь нь өөрийн цахим хуудастай, 48 хувь нь фэйсбүүк хуудастай, 19 хувь нь твиттер хаягтай байна. Телевиз, радио ч мөн өөрийн цахим сайт, олон нийтийн сүлжээнд хуудастай. Интернет, вэб сайтууд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болоод зогсохгүй хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийг хооронд нь нэгтгэхэд нөлөөлж байна.

Сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбар цахимжих давалгаа хэвлэл мэдээллийн хэвшмэл дүр зургийг асар богино хугацаанд өөрчлөхийн зэрэгцээ мэдээлэл түгээх болон хадгалах орон зайг хил хязгааргүй болгож өгсөн. Чөлөөт хэвлэл, интернет сэтгүүл зүйн эрх чөлөө хүчээ авч өнөөдөр Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө харьцангуй өндөр үзүүлэлттэй байна.

"Baidu" хайлтын систем нь БНХАУ-ын интернет хэрэглээний хамгийн алдартай сайт юм. Хятад хэлээрх өргөн хайлтын хамгийн тэргүүлэх систем бөгөөд "энгийн, найдвартай" хэмээх тодотголтой. Дуу хөгжим, кино, мэдээллийг үзэх сонсох, унших боломжтой бөгөөд анх удаа БНХАУ-д гар утсаар WAP болон PDA суурилсан хөдөлгөөнт хайлт хийх нөхцөлийг бүрдүүлж өгчээ. "Baidu" хайлтын систем нь 57 төрлийн хайлтыг хятад хэлээр хайх боломжтой бөгөөд интернет дэх нийт лавлагааны 8 хувийг гүйцэтгэдэг.

"Baidu"-ийн 2016 оны орлого өнгөрсөн онтой харьцуулахад 52 хувиар өсчээ. Гэхдээ энэ нь урьдчилсан таамагт хүрээгүй учраас хувьцааны ханш нь суларсан байна.

Түүнчлэн өнгөрсөн 2016 онд "Baidu" компани 13.52 тэрбум юанийн орлоготой ажилласан нь тус компанийн түүхэн дээд үзүүлэлт болжээ. 2016 оны БНХАУ-ын нийт интернет хандалтын 76.2 хувийг "Baidu" бүрдүүлж байсныг "Bloomberg Intelligence"-ийн тооцоо үзүүлсэн байна.

Интернет өөрөө дүрс бичлэг, зураг, бичвэр зэрэг олон зүйлээс бүрдсэн нийлмэл цогц орчин. Цахим сэтгүүл зүй сэтгүүлчээс интернетэд бичвэр, дуу, дүрс, компьютер, програм хангамжийг зөв ашиглах чадварыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл мэдээллийг дан ганц

хэлбэрээр бус олон элементийн тусламжтайгаар цогц хүргэх "мультимедиа сэтгүүлч" байх чадварыг шаардаж байна. Мөн хамгийн чухал нь цахим сэтгүүл зүйн хөгжлийг зөв чиглэлд чиглүүлэх дараах шаардлага зүй ёсоор оршиж байна. Үүнд мэргэжлийн байдал, ёс зүй, нийгмийн хариуцлагын асуудал хамаарна.

**И**нтернет хэрэглээний давуу талыг ашиглан сэтгүүл зүйн жорыг ихэд хялбарчлан ойлгосон мэргэжлийн бус хэсгийнхэн цахим сэтгүүл зүйн салбарт түрэн орж ирж, улмаар салбарын бүтээгдэхүүний чанар чансаа суларч, сайн технологи, буруу арга барил хосолсон шүүлтүүргүй, үнэн бодитын шалгуургүй асар их мэдээллийн ертөнц автоматаар бий болсон. Үр дагаварт нь олон нийтийн дунд сэтгүүл зүйн салбарын нэр хүнд унаж, мэргэжлийнхэнд мэргэжлийн бус хэсгээс ялгарах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Интернетийн орчин дахь мэдээллийн харилцааг улс орон бүр ямар нэг хэмжээгээр хууль, эрх зүйн зохицуулалттай болгохыг эрмэлзэж байна. Монголын нөхцөлд интернетийн орчинг мэдээллийг орчин болгох эрх зүйн орчин дутмаг бөгөөд мэдээллийн хязгааргүй орон зайд сэтгүүл зүйг ялгах, түүнийг судлах, хөгжүүлэх судалгаа хангалттай хийгдээгүй байна. Интернет нь мэдээллийн хэрэгсэл болохоос мэдээллийн байгууллага бус. Энэ ойлголтыг ялгах гарц нь эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх явдал юм.

Сэтгүүл зүйд хуулийн хамгаалалтаас гадна салбарын өөрийн соёл дархлаа болох ёстой. Сэтгүүлчдэд мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх ёс зүй байх ёстой. Цахим сэтгүүл зүй салбарын хувьд тулгарч буй гол

асуудлын нэг бол оюуны өмчийн асуудал. Вэб сайтууд зохих зөвшөөрөлгүйгээр мэдээ, нийтлэл хуулбарлан байршуулж, зохиогчийн эрхийг зөрчих хандлага түгээмэл байна. Өдөр тутмын мэдээний хувьд зохиогчийн эрхийн зөрчлийн тухай ярих хэцүү ч сэтгүүлчийн оюуны ур чадвар бүхий нийтлэлийн хувьд түүн дээр зохиогчийн эрхийн хамгаалалт яригдах ёстой.

**С**этгүүл зүйн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалах эсэх, бусдын зохиогчийн эрхийг интернет сэтгүүл зүйд хэрхэн хангах вэ гэдэг талаар сэтгүүлчдийн мэдлэг, ур чадвар харилцан адилгүй байна. Тухайлбал, вэб сайт дахь мэдээ, нийтлэлд эх сурвалжаа холбоос ашиглан шууд зааж өгөх боломжтой. Ийм холбоосгүй мэдээ, материал нь бусдын зохиогчийн эрхийг зөрчсөн байх магадлалтай бөгөөд холбоос нь шаардлага хангахгүй, хуучирсан, хувь хүний мэдээллийг татан оруулсан зэрэг зөрчил түгээмэл байна.

Мэдээллийн сайтууд улс төрийн нөлөөлөлд автах, мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах хаалтын гэрээ байгуулах замаар захиалгат, хараат сэтгүүл зүй ноёрхох хандлага байна. Чөлөөт хэвлэл бүрэлдэн тогтож, улмаар нийгмийн хөгжил төлөвшилд хувь нэмрээ оруулах учиртай.

Хараат бус сэтгүүл зүй оршин тогтнохын үндэс нь бизнесийн эрүүл орчин юм. Иймд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллага өөрсдөө мөнгө олох, оюуны өмч, бизнесийн орчноо сайжруулах өөрчлөлт шинэчлэлийг эхлүүлэх ёстой. Хэвлэл мэдээллийн байгууллагын хэм хэмжээг тодорхойлж, эрүүл бизнесийн зарчмаар оршин тогтонодог, хараат бус, үнэ цэнэтэй сэтгүүл зүй хөгжинө.

Цахим сэтгүүл зүй бол Хятадад шинэхэн хөгжиж эхэлсэн хүчирхэг мэдээллийн хэрэгсэл бөгөөд нийгэмд үзүүлж буй нөлөөллийг эерэгээр төлөвшүүлэх нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч бидний эрхэм үүрэг юм.

БНХАУ-ын хамгийн том бөгөөд түгээмэл хэрэглэгддэг интернет үйлчилгээ бөгөөд 1998 онд "Tencent" ХХК бүтээжээ. Одоогоор "нэг цэгийн онлайн үйлчилгээ" хэмээн хэрэглэгчдийг хэрэгцээг хангах стратегийн зорилтыг өөрийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийг зорьдог байна. QQ.com, QQ тоглоом, болон PaiPai.com нь Хятадын хамгийн том цахим орон зайн харилцааг бий болгожээ. Түүнчлэн "Tencent"-ийн платформ нь харилцаа холбоо, мэдээлэл солилцох үйлчилгээний QQ.com, шуурхай элч QQ mail болон хайлтын SOSO багтдаг. Иймд QQ шоуны, QQ амьтны, QQ тоглоомны болон QQ хөгжимийн /радио/ зэрэг виртуал бүтээгдэхүүн Live хэрэглэгчдэд үзвэр, өөрчлөх боломжуудыг хангадаг. Мөн гар утас хэрэглэгчдийн нэмүү өртөг шингэсэн утасгүй үйлчилгээний хэд хэдэн давуу талыг ашиглах боломжтой болгожээ. Эдгээрээс онцлоход QQ мэссэнжэрийн хэрэглэгчдийн тоо 990.0 сая хүрсэн бөгөөд идэвхитэй хэрэглэгчид 448.0 сая болсон байна.

Тиймээс бид алсыг харж оюуны өмчийг хүндэтгэн хамгаалдаг, эх сурвалжийг бичих арга зүйд суралцаж хэвшсэн, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн дээдэлдэг цахим сэтгүүлчдийг төлөвшүүлэн цахим сэтгүүл зүйг мэргэжлийн, ёс зүйтэй, нийгмийн хариуцлагатай хөгжүүлэх ёстой.

**Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Хэвлэлийн хүрээлэн. УБ. 2016
2. Б.Болд-Эрдэнэ. Интернет сэтгүүл зүй. УБ. 2009
3. Фредрих Эбертийн сан.Азийн хэвлэл мэдээллийн барометр.УБ. 2012
4. Б.Галаарид. “Цахим сэтгүүл зүй манай салбарын ирээдүй” илтгэл. УБ. 2015